



ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ТӨСВИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Аудитор

Ж.Бямбацогт

Утас: 70273463 96455444

И-Мэйл: j.beegii@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

2015 оны 3 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Аргалант сумын ЕБС-ийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2015/04/СТА-ТТЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аргалант сумын ЕБС-ийн төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аргалант сумын ЕБС-ийн 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 19-нээс 2015 оны 03 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Ж.Бямбацогт хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Аргалант сумын ЕБС-ийн 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 03 дугаар сарын 10-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 19-нээс 2015 оны 03 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 03 дугаар сарын 25-нд Аргалант сумын ЕБС-ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцох тухай” журмыг 2014 оны 297 дугаар тогтоолоор хүчингүй болгосон байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 4.1-д “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг

ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 2-д “Боловсролын байгууллага нь улсын төсөв, хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс оруулах сургалтын төлбөр, дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, хөнгөлөлттэй зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй байна.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Аргалант сумын ЕБС-ийн дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг БШУЯ-аас баталж Аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хуулиуд бүрэн хэрэгжиж, Сангийн сайдын тушаал, журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Аргалант сумын ЕБС-ийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Аргалант сумын ЕБС-ийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын 6 горим, нарийвчилсан 2 сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн асcolous програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Аргалант сумын ЕБС-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Аргалант сумын ЕБС-ийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2014 онд улсын төсвөөс урсгал 387669.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс урсгал зардалд 387454.1 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 99.8 хувь зарцуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 6, нарийвчилсан 2, нийт 8 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1885.6 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнаагүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагын бэлэн мөнгөний орлогын баримт байхгүй 3431.5 мянган төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч гүйлгээ хийсэн, бараа материалын дансанд 1659.6 мянган төгрөгийн хий орлого авч тайлагнасан, 7092.7 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй шууд зардалд бичсэн, 60.0 мянган төгрөгийн илүү төлөлт хийж авлагаар тайлагнаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Аргалант сумын ЕБС-ийн төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, томилолт, гэрэл цахилгаан, халаалт, цалин зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 95.02 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний 15101.3 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. 7092.7 мянган төгрөгийн материалыг бараа материалын дансанд бүртгээгүй шууд зардалд бичсэн, 1659.6 мянган төгрөгийн бараа материал, хөрөнгө хий орлогод авсныг тооллогын бүртгэлээр баталгаажуулсан нь УСНББОУС 12 “Бараа материал”, НББ-ийн тухай хуулийн 9.1, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Бараа материалыг данс бүртгэлд авч тайлагнаж байх зөвлөмж, 1659.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авах албан шаардлага бичив.

2. 1885.6 мянган төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдлийг тайлагнаагүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагын бэлэн мөнгөний орлогын баримт байхгүй 3431.5 мянган төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 7.7, НББ-ийн тухай хуулийн 9.1, 7.1, 7.4, 19.1.5 заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Анхан шатны баримтыг үндэслэж гүйлгээ хийж байх, хэмнэгдсэн төсвийг төвлөрүүлэх зөвлөмж өгөв.

3. НД-ын улсын байцаагчийн тавьсан 1031.9 мянган төгрөгийн актын төлбөрийг төсвийн хөрөнгөөр барагдуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, 41.2.2 дах заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: 1031.9 мянган төгрөгийн албан шаардлага бичив

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Цахилгааны зардлаас 2250.0 мянган төгрөгийг хоолны зардалд гүйлгэн зарцуулсан, ММНБИ-ийн Төв аймаг дахь салбарт нярвын сургалтын төлбөр 60.0 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, 16.5.5, 41.2.2 НББ-ийн тухай хуулийн 9.1 Сангийн сайдын 2013 оны 273 тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: 60.0 мянган төгрөгийн акт, 2250.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэв.

2. Бага ангид үнэгүй тараагдах 1323.3 мянган төгрөгийн үнэ бүхий номыг орлогод авч тайлагнаагүй, бусад хангамжийн материалд 3082.4 мянган төгрөгийн хүнсний материал, хөрөнгө орлогод авсан нь УСНББОУС 12 “Бараа материал”, НББ-ийн тухай хуулийн 9.1, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: 1323.3 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 3082.4 мянган төгрөгийн албан шаардлага бичив.

3. 21194.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг өглөг дансаар дамжуулалгүй журналын бичилт буруу хийсэн, цалин бодож олгохдоо цалингийн өглөг дансаар дамжуулалгүй

7455.9 мянган төгрөгийг шууд зардалд бичсэн нь УСНББОУС 12 “Бараа материал”, НББ-ийн тухай хуулийн 9.1, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулж хийх байх зөвлөмж өгөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно. Материаллаг бус 1323.3 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж бараа материалын дансыг завсрын аудитаар шалгахаар болов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аргалант сумын ЕБС-ийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 50467.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 41059.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 8023.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 60.0 мянган төгрөгийн акт бичлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Аргалант сумын ЕБС-ийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд Аудитын газраас хийсэн аудитаар 1 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт: **Хязгаарлалттай санал дүгнэлт**

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Аргалант сумын ЕБС-ийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 5 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Ж.БЯМБАЦОГТ

2015 оны 03 сарын 25